

Мэндчилгээ



“Хотол төгс” хэмээх төмөр хулгана жилийн мэнд дэвшүүлье. Өнгөрөгч 2019 он АМЕП хөтөлбөр хоёрдугаар шатаа эхлүүлсэн амжилттай жил байлаа.

АМЕП хөтөлбөр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншүүдтэйгээ тогтоосон харилцаа холбоон дээрээ үндэслэн, 2020 онд Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгынхоо төлөө үргэлжлүүлэн ажиллах болно. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгынхоо хүрээнд бид зургаан төсөл хэрэгжүүлж байна. Үүнд Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулах, шинэчлэгдсэн татварын хуульд заасан үнэ шилжилтийг зохицуулсан заалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Монголын геологийн мэдээллийн каталоги системд мэдээлэл оруулах, нүүрсний давхаргын метан хийн талаарх Австралийн эрх зүйн орчны туршлагаас хуваалцах, “хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг хэрэгжүүлэх заавар боловсруулах, техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийхтэй холбоотой дүрэм журам сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажил багтаж байна.

Энэхүү мэдээллийн товхимлын өмнөх дугааруудад АМЕП 2-ын хэрэгжүүлж буй хоёр төслийг танилцуулсан. Энэ удаагийн дугаараас та бүхэн ТЭЗҮ-тэй холбоотой дүрэм журам сайжруулах тал дээр бид ямар үр дүнд хүрэхээр ажиллаж буйг уншиж сонирхоорой.

Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) гэж юу вэ?

- Техник, эдийн засгийн үндэслэлүүд нь хүдрийн биетэд хамаарах техникийн ба эдийн засгийн өгөгдлүүдийг агуулах бөгөөд түүнийг ашиглах боломжийн талаарх олборлолт, боловсруулалтын аргууд, байгаль орчинд үзүүлэх нөлөө, хаягдлын менежмент зэрэг асуудлыг багтаана.
- Техник, эдийн засгийн үндэслэлд олборлох эрх ба зөвшөөрөл, хайгуулын түүх, геологи, хүдрийн нөөц, дэд бүтцийн төлөвлөгөө, аюулгүй ажиллагаа, эрсдлийн менежмент, эдийн засаг, санхүүгийн үнэлгээ, төсөл хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн гаргах хуваарь, уурхайн зураг төсөл, байгаль орчны менежмент, хүдэр баяжуулалт, боловсруулах төлөвлөгөө орно.

ТЭЗҮ-ийг хэн боловсруулдаг вэ?

2012 онд батлагдсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн ТЭЗҮ-д тавигдах шаардлага ба ТЭЗҮ хүлээн авах журам”-ыг шинэчлэх ажлын хэсэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр байгуулагдан ажиллаж байна. АМЕП 2 хөтөлбөр нь ажлын хэсэгтэй ТЭЗҮ-тэй холбоотой олон улсын туршлагын талаар мэдээлэл хуваалцан хамтран ажиллаж байна. ТЭЗҮ-д тавигдах шаардлага, түүнийг боловсруулах, ТЭЗҮ хүлээн авах зэрэг нь нарийн төвөгтэй асуудал бөгөөд шинэчлэл хийхэд цаг хугацаа шаардагддаг. Эхний ээлжинд, дүрэм журмаа өөрчилж, үйл явцаа илүү үр дүнтэй болгон, стандартаа өндөрсгөх нь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулна.

2012 оны журмыг бүх төрлийн ашигт малтмалын урьдчилсан судалгаа, ашигт малтмал, хүдрийн ордын нөөцийг орон зайн хэмжээст тодорхойлсны дараа хийгддэг урьдчилсан ТЭЗҮ, уурхайн төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад хэрэглэж байна. Энэ журам нь төсөл хөгжүүлэгч ба хэрэгжүүлэгчдэд тавих шаардлагыг мөн зохицуулдаг.

Үргэлжлэл т.2 ►►

ТЭЗҮ-ийг Монгол болон гадаадын улс орнууд хэрхэн хийдэг вэ?

Ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор 2012 оны журамд нийцүүлэн ТЭЗҮ боловсруулсан байх ёстой. Монгол Улсад ашигт малтмалын нөөцийн тайлан дээр үндэслэн гаргасан ТЭЗҮ-г хянах, хүлээн авах үүргийг төрийн байгууллага болох Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хариуцдаг.

Харин барууны орнуудад ТЭЗҮ-ийн агуулга нь зээлдэгч ба хөрөнгө оруулагчдын шаардлагыг хангаж байдаг. Засгийн газар ба зохицуулагч байгууллагууд ТЭЗҮ-д зориулж стандарт тогтоодоггүй, мөн баталдаггүй.

Барууны орнууд ТЭЗҮ-ийг төслийн санхүүжилт зохицуулахад голлон ашигладаг. Монгол улсад ТЭЗҮ нь зохицуулалтын үйл явцын нэг хэсэг байдаг ба засгийн газрын төлөвлөлтөд ашигладаг.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, мэргэжлийн холбоодын дэмжлэгтэйгээр, АМЕП 2 оролцогч талуудад барууны орнуудад хэрэглэгддэг ТЭЗҮ-ийн туршлагаас хуваалцаж, дугуй ширээний уулзалт ярилцлага, сургалт зохион байгуулаад байна.

Барууны орнуудад Техник, эдийн засгийн үндэслэлийн агуулгын цар хүрээ ба нарийвчлалын шаардлага улам бүр нэмэгдэж, стандартчлагдаж ирсэн байна. Хөгжлийн энэ чиг хандлагыг дагаж, Америкийн зардлын шинжээч инженерүүдийн холбоо шаардагдах мэдээллийн цар хүрээ, нарийвчлалыг тусгасан судалгааны элементүүдийг гүнзгийрүүлж байгаа нь өргөн хэрэглэгдэх болоод байна.

Техник, эдийн засгийн үндэслэлийн агуулга нь шаардагдах нарийвчлалын түвшинг дэмжинэ. Америкийн зардлын шинжээч инженерийн холбоо дараах нарийвчлалын түвшинг тогтоосон:

- Урьдчилсан судалгаа: +/- 30 - 35%;
- Урьдчилсан ТЭЗҮ: +/- 20 - 25%;
- ТЭЗҮ: +/- 10 to 15%.

Техник, эдийн засгийн үндэслэлийг шаардагдах нарийвчлалын түвшинд хийж гүйцэтгэхийн тулд зардлыг зохих ёсоор нарийвчлан тооцоолох ёстой. Мөн эрсдлийн иж бүрэн шинжилгээг заавал хийнэ. Барууны орнуудад хэрэглэгддэг ТЭЗҮ болон МУ-д ТЭЗҮ боловсруулахад тавигддаг шаардлагын хооронд эдгээр ялгаа байна гэж үзэж байна.

Дараагийн алхам

АМЕП 2 хөтөлбөр нь олон улсын туршлага дээр үндэслэн хийсэн харьцуулсан үнэлгээ, Монгол Улсын дүрэм журамд оруулж болох шинэчлэлтийн талаарх саналаа яамны ажлын хэсэгт хүргүүлэхээр төлөвлөж байна.

2020 оны эхний хагаст ажлын хэсэг дахин уулзаж зөвлөлдөнө. Олон улсын зөвлөх Стив Гемелл 3 дугаар сард МУ-д дахин ирэхдээ олон улсын туршлагаас Монгол Улсад тохиромжтой байж болох зохицуулалтын талаар оролцогч талуудтай санал солилцоно.



-- МАНАЙ ЗОРИЛТ:

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар МУ-ын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах